



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 09

Мөрөн

**“Хөвсгөлийн эмийн эргэлтийн сан”
ОНӨХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн
цалин тогтоох, 2021 оны зардал батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 02 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Хөвсгөлийн эмийн эргэлтийн сан” ОНӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг 26,239,200 (Хорин зургаан сая хоёр зуун гучин есөн мянга хоёр зуун) төгрөгөөр, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн нэг сард олгох цалинг 130,000, нарийн бичгийн даргын цалинг 650,000 төгрөгөөр тогтоож, хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан цалинг 2021 оны 01 дүгээр сараас эхлэн ажлын тайлан үр дүнг дүгнэж, тооцож олгохыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Болд), Компанийн гүйцэтгэх захирал, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3. Компанийн удирдлагын зардлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Цалин урамшууллын хороонд даалгасугай.


ДАРГА



Г.МӨНГӨНХУЯГ

110150024

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 18–ны
өдрийн 09 дүгээр тогтоолын хавсралт



“Хөвсгөлийн Эмийн эргэлтийн сан”
ОНӨХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн
2021 оны зардлын төсөв

Д/д	Зардлын төсөв	Сард	Нийт зардал
1	ТУЗ-ийн дарга, гишүүд -9	130,000	14,040,000
2	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга-1	650,000	7,800,000
3	ТУЗ-ийн цалингийн зардал		21,840,000
4	НДШ		2,839,200
5	Бичиг хэргийн зардал		450,000
6	Шуудан холбооны зардал		200,000
7	Хурлын зардал		300,000
8	Томилолт		360,000
9	Шатахуун		250,000
	ДҮН		26,239,200

_____ оОо _____